

УУРАГ-ВИТАМИНТ НУХАШ БЭЛТГЭХ

Мал сүрэг тэжээлийн хомсдол төдийгүй Х сараас дараа оны Y-YI сар хүртэл (240-270 хоног) бэлчээрийн дан хагд буюу борог өвсөөр хооллох бөгөөд энэ хугацаанд чухал шаардлагатай шимт бодис (уураг, хялбар уусах нүүрсус), биологийн идэвхт бодис (витамин, фермент, гормон) дутагдан зун, намар хуримтлуулсан энерги болох тарга хүчнийхээ 25-30 хувийг алдаж онд ордог. Иймээс чанар сайтай тэжээл бэлтгэхэд анхаарвал зохино.

Уураг-витаминт нухаш:

Нухаш нь ногоон ургамал дахь шимт ба биологийн идэвхт, эрдэс бодисыг алдагдал багатай удаан хугацаагаар нөөцлөн хадгалах арга болно.



Уураг, хялбар шингэх нүүрсус, витамины агууламж сайтай царгас, хүцэнгэ, хошоон, халгай, бууцны хөх ногоон хиаг, таана, хөмүүл, мангир болон таримал нэг, олон наст ургамал залуу ногоон масс ашиглан бэлтгэнэ. Таана, хөмүүл, мангирийг цэцэглэлтийн өмнөх үед, халгайг 15-20 см өндөр болмогц, таримал нэг, олон наст үет ургамлыг бутлалт, буурцагт ургамлыг салаалалтын үед хураана.

Уураг-витамин агууламж сайтай хэд хэдэн ургамлын хольцоор бэлтгэх боломжтой. Тэжээлийн ногоон ургамлыг хадангуут ДКУ-03 болон адил төстэй машинд оруулан таташ гаргаж авна. Татшаа сайтар давслан шүүс гарахгүй болтол эврээнэ. Халуун ус, уураар ариутгасан пластмасан торх, ундааны лонхонд сайтар чигжиж нягтруулан бүрэн дүүргэж савлана. Зузаан плёнкон уутанд хиад адил хадгалж болно. Ямар ч хэмжээтэй тухайн савыг өдөрт нь дүүргэж агаар, бохир зүйл орохооргүй бин битүү таглах хэрэгтэй. Энэхүү ундааны лонхонд савласан нухашийг халуун усанд хийх, эсвэл бууз адил уураар жигнэж ариутгана. Харин том саванд хийж хадгалах бол нухашаа урьдчилан ариутгаж хийнэ. Үүний тулд нухашаа цэвэрхэн тогоонд хийж сайтар халааж (70-80°C) савлана. Нухашийг сэрүүн, харанхуй газар хадгална.

Өвөлжөө, хаваржааны дэргэд газар нүхэнд хадгалвал илүү тохиромжтой. Нухашийг 10-12 сар хадгалах боломжтой. Нухаш нь бор ногоон өнгөтэй, анх ашигласан ногоон ургамлын анхилуун сайхан үнэртэй, мал дуртай идэж байвал зохино. Хээлтэй ба төллөсөн эх мал, нэг наст мал, борог тэжээл орсон нялх төл тэжээнэ. Хоолны шөлөнд бага зэрэг хийх байдлаар өгвөл үр дүн бүр ч илүү байна. Төллөх бог малд өглөө, орой тус бүр 0.2-0.3 кг, бод малд 3-4 кг өгнө. Нухашийг халуун усанд хийж хандлан мал услах, уг хандаараа багсармал холимог тэжээл чиглэх аргаар хэрэглэнэ.

Боловсруулсан: МААЭШХ-ийн Эрдэм
шинжилгээний ажилтан Л.Алтанцэцэг